НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР
Нийслэлийн засаг захиргааны IV байр, Бага тойруу-15,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0066
Утас: 7575-7807, Факс: (976) 7575-7809
E-mail: contact@ub-procurement.mn
http://www.ub-procurement.mn

2020.10.02 № 02/2034

танай ______________-ны №______________-т

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр зарласан БХБЯ/202001187 дугаартай Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгын судалгаа загвар төсөл, гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажлын ТШӨХ-ийн ТӨЗ 2.1 заалтад 2020 онд санхүүжих мөнгөн дүнд Барилга, Хот байгуулалтын сайдын 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 179 дугаартай тушаалаар өөрчлөлт орсоныг үүгээр мэдэгдэж байна.

Хавсралт 4 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ч.НЯМ-ОЮУН

УХА0517 5664225

1150500770

D:\Gargah\2020\1-37\2034.docx

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 25 өдөр Дугаар 179 Улаанбаатар хот

Тушаал шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 71.2, Засгийн газрын 2020 оны 168 дугаар тогтоолын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар Барилга, хот байгуулалтын сайдын багцад хэрэгжихээр батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн зохицуулалтын саналыг 1 дүгээр хавсралтаар, 2020 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралт дахь хөрөнгө оруулалтын жагсаалтын XI.1.5-д батлагдсан "Газрын төлөвлөлт, бүртгэл, бирж, үнэлгээ, мониторингийн нэгдсэн тогтолцоог бий болгох /улсын хэмжээнд/" төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдэх ажлын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар, XI.1.23-д батлагдсан "Монгол Улсын хүн амын нутагшил, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулах /Улсын хэмжээнд/" төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдэх ажлын жагсаалтыг 3 дугаар хавсралтаар, XI.1.24-т батлагдсан "Нийслэл, аймгийн төвүүдийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлт /Улсын хэмжээнд/" төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдэх ажлын жагсаалтыг 4 дүгээр хавсралтаар, XI.1.25-д батлагдсан "Нийслэл, аймгийн төвүүдийн үерийн хамгаалалтын шинэчлэлт, зураг төсвийн хамт /Улсын хэмжээнд/" төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдэх ажлын жагсаалтыг 5 дугаар хавсралтаар, XI.1.41-т батлагдсан "Төв цэвэрлэх байгууламжийн лагийг цэвэрлэж, үнэргүйжүүлэх /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/" төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдэх ажлын жагсаалтыг 6 дугаар хавсралтаар, XI.1.11-т батлагдсан "Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ /Ховд, Жаргалант сум/" төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдэх ажлын жагсаалтыг 7 дугаар хавсралтаар, XI.1.30-д батлагдсан "Сумын төвийн инженерийн нэгдсэн шугам сүлжээ /цэвэр, бохир ус болон дулаан, дулааны эх үүсвэр/ /Ховд, Булган сум/" төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдэх ажлын жагсаалтыг 8 дугаар хавсралтаар, XI.1.55-д батлагдсан "Шинэ хороо" төсөл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 7, 8, 9, 10, 11 дүгээр хороо/" төсөл, арга хэмжээний жагсаалтыг 9 дүгээр хавсралтаар, XI.1.58-д батлагдсан "Барилга, хот байгуулалтын салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалт /Улаанбаатар/" төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдэх ажлын жагсаалтыг 10 дугаар хавсралтаар, XI.1.91-д батлагдсан "Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөрийг хэрэгжүүлэх /Улсын хэмжээнд/" төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдэх ажлын жагсаалтыг 11 дугаар, XI.1.97-д батлагдсан "Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хийгдэх инженерийн шугам сүлжээ /Улаанбаатар/" төсөл, арга хэмжээний жагсаалтыг 12 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

151010546

2. Уг тушаалын хавсралтуудаар батлагдсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд чиглэлийн дагуу хяналт тавьж ажиллахыг холбогдох газрын дарга нарт, батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Санхүүгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий санхүүч /С.Должинсүрэн/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Магнайсүрэн/-д даалгасугай.

Б.МӨНХБААТАР

Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 173 дугаар тушаалын 10 дугаар хавсралт

**Барилга, хот байгуулалтын салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалт /Улаанбаатар/ төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдэх ажлын жагсаалт**

сая.төг

| Д/д | Төсөл, арга хэмжээний нэр, байршил | Хугацаа | | Төсөвт өртөг | 2020 онд санхүүжих |
|---|---|---|---|---|---|
| | | Эхлэх | Дуусах | | |
| XI.1.58 | **НИЙТ ДҮН** | | | **25,000.0** | **5,700.0** |
| XI.1.58.1 | Гэр хороолол, орон сууцны дэд бүтцийн ажил | 2020 | 2021 | 5,000.0 | 1,645.2 |
| XI.1.58.2 | Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгын судалгаа загвар төсөл, гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил | 2020 | 2021 | 1,500.0 | 188.0 |
| XI.1.58.3 | Төв цэвэрлэх байгууламжийн лаг хатаах байгууламжийн эхний ээлж | 2020 | 2021 | 2,000.0 | - |
| XI.1.58.4 | Нийтийн зориулалттай орон сууцны барилгын цахилгаан шат | 2020 | 2021 | 1,120.0 | 300.0 |
| XI.1.58.5 | Нийтийн зориулалттай орон сууцны барилгын дээвэр | 2020 | 2021 | 1,500.0 | 714.0 |
| XI.1.58.6 | Нийтийн зориулалттай орон сууцны барилгын фасад | 2020 | 2021 | 1,000.0 | 356.0 |
| XI.1.58.7 | Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, гэр хороолол, орон сууцны хорооллын гэрэлтүүлэг | 2020 | 2021 | 1,000.0 | 595.2 |
| XI.1.58.8 | Ус зөөврийн автомашин /3ш/ | 2020 | 2021 | 450.0 | 136.0 |
| XI.1.58.9 | Төвлөрсөн дулаан хангамжийн нэгдсэн системд холбогдох боломжгүй алслагдсан халаалтын зуухыг шинэчлэх, байгальд ээлтэй технологи, нэмэлт тоноглол суурилуулах | 2020 | 2021 | 500.0 | - |
| XI.1.58.10 | Хог хаягдлын эко төсөл хэрэгжүүлэх | 2020 | 2021 | 700.0 | 20.0 |
| XI.1.58.11 | Барилга, байгууламжийн газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийж паспортжуулах ажил | 2020 | 2021 | 200.0 | 100.0 |
| XI.1.58.12 | Хот тохижилтын тусгай зориулалтын автомашин, техник хэрэгсэл, машин механизм | 2020 | 2021 | 5,600.0 | 400.0 |
| XI.1.58.13 | Үерийн хамгаалалтын далан /СХД, 3,4 дүгээр хороо/ | 2020 | 2021 | 630.0 | 273.0 |
| XI.1.58.14 | "Насос станц №7-н өргөтгөл шинэчлэлтэй уялдуулсан нам цэгийн шугам"-ын ажил / Улаанбаатар, Хан-уул дүүрэг/ | 2020 | 2021 | 3,300.0 | 922.6 |
| XI.1.58.15 | Халуун усны барилга / Улаанбаатар, Хан-уул дүүрэг, Биокомбинат/ | 2020 | 2021 | 500.0 | 50.0 |

ooooooooOoooooo

Хавсралт 2

## МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИАР 2020 ОНД САНХҮҮЖИХ ДҮН БУУРСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

/Сая төг/

| № | ТЕЗ | Хуулийн дугаар | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа | Анх батлагдсан | | Өөрчлөлт оруулах тухай хуулиар | | Зөрүү |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Төсөвт өртөг | 2020 онд санхүүжих дүн | Төсөвт өртөг | 2020 онд санхүүжих дүн | |
| 1 | ЗГХЭГ-ын дарга | IV.1.39 | Хорооны цогцолбор барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 9 дүгээр хороо/ | 2020 | 2021 | 1,800.0 | 215.5 | 1,800.0 | 100.0 | -115.5 |
| 2 | ЗГХЭГ-ын дарга | IV.1.38 | Хорооны цогцолборын барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 10 дугаар хороо/ | 2020 | 2021 | 1,800.0 | 800.0 | 1,800.0 | 100.0 | -700.0 |
| 3 | ЗГХЭГ-ын дарга | IV.1.3.15 | Хорооны Засаг даргын Тамгын газрын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 18, 19, 23, 27, 29, 38, 39 дүгээр хороо/ | 2020 | 2020 | 100.0 | 100.0 | 95.0 | 95.0 | -5.0 |
| 4 | ЗГХЭГ-ын дарга | IV.1.3.23 | Хорооны цогцолборын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 10 дугаар хороо/ | 2020 | 2020 | 200.0 | 200.0 | 195.0 | 195.0 | -5.0 |
| 5 | БОАЖС | V.1.17 | Соёл, спорт, аялал жуулчлалын цогцолборын хувцас солих байр, тусламж үйлчилгээ, нийтийн соёл үйлчилгээний барилга байгууламж, өвлийн спортын талбай /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 19 дүгээр хороо, дээд Салхит/ | 2020 | 2021 | 2,900.0 | 1,500.0 | 2,900.0 | 500.0 | -1,000.0 |
| 6 | БОАЖС | V.1.19 | Хороодын ногоон байгууламж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 6, 15, 18, 25, 26 дугаар хороо/ | 2020 | 2020 | 1,000.0 | 1,000.0 | 947.0 | 947.0 | -53.0 |
| 7 | БХБС | XI.1.22 | Инженерийн шугам сүлжээний шинэчлэлт /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо/ | 2019 | 2020 | 2,000.0 | 1,000.0 | 1,800.0 | 800.0 | -200.0 |
| 8 | БХБС | XI.1.27 | Нийтийн эзэмшлийн орон сууцын байруудын дулааны шугам сүлжээ, дэд станц /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 11, 15 дугаар хороо/ | 2018 | 2021 | 6,453.8 | 3,853.8 | 6,453.8 | 1,926.9 | -1,926.9 |
| 9 | БХБС | XI.1.58 | Барилга, хот байгуулалтын салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалт /Улаанбаатар/ | 2020 | 2021 | 25,000.0 | 25,000.0 | 25,000.0 | 5,000.0 | -20,000.0 |
| 10 | БХБС | XI.1.68 | Жишиг гудамж төсөл - 2 /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 14 дүгээр хороо/ | 2020 | 2021 | 3,300.0 | 3,300.0 | 3,300.0 | 50.0 | -3,250.0 |
| 11 | БХБС | XI.1.77 | Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20 дугаар хороо/ | 2020 | 2021 | 1,640.0 | 640.0 | 1,640.0 | 50.0 | -590.0 |
| 12 | БХБС | XI.2.5 | Орон сууцын байруудын их засвар /Улаанбаатар, Багахангай дүүрэг, 1 дүгээр хороо/ | 2019 | 2020 | 3,886.1 | 1,386.1 | 3,886.1 | 886.1 | -500.0 |
| 13 | БХБС | XI.2.10 | Гадна талбайн тохижилт /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4, 5, 14 дүгээр хороо/ | 2020 | 2021 | 600.0 | 600.0 | 600.0 | 50.0 | -550.0 |
| 14 | БХБС | XI.2.22 | Нийтийн эзэмшлийн орон сууцын гадна талбайн тохижилт /Улаанбаатар, Багануур дүүрэг, 1 дүгээр хороо/ | 2020 | 2021 | 650.0 | 300.0 | 650.0 | 50.0 | -250.0 |
| 15 | БХБС | XI.2.25 | Нийтийн эзэмшлийн орон сууцын дээврийн засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 10 дугаар хороо, 2А хэсгийн 5, 10, 17 дугаар байр/ | 2020 | 2020 | 106.9 | 106.9 | 97.0 | 97.0 | -9.9 |
| 16 | БХБС | XI.2.31 | Нийтийн эзэмшлийн орон сууцын орцын их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 7, 8, 9, 10 дугаар хороо/ | 2020 | 2021 | 900.0 | 600.0 | 900.0 | 420.0 | -180.0 |
| 17 | БХБС | XI.2.23 | Нийтийн эзэмшлийн орон сууцын гадна фасадын их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 7, 8, 10 дугаар хороо/ | 2020 | 2021 | 400.0 | 400.0 | 400.0 | 280.0 | -120.0 |
| 18 | БХБС | XI.2.32 | Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 13, 14 дүгээр хороо/ | 2020 | 2021 | 80.0 | 80.0 | 80.0 | 50.0 | -30.0 |